

БАТЛАВ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА

БАТЛАВ  
ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРАЛ

Г.УЯНГА

### ГАДААД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2017 оны 11 дугаар 24 сарын ... өдөр

Дугаар№

Улаанбаатар хот

2017 1 1 27 1 4 4

#### ӨМНӨТГӨЛ

##### Нэг талаас:

Монгол улс, Улаанбаатар хот, СБДүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж, 136 хаягт орших, РД:9086331 дугаартай "ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" /цаашид А тал гэх/, түүнийг төлөөлж: Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн албаны даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч З.Наранбаатар

##### Нөгөө талаас:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Дун талын ...  
... түүнийг төлөөлж: Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн албаны даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч З.Наранбаатар

#### Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "А тал гэх/" -ийг төлөөлж Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны дарга З.Наранбаатар нөгөө талаас Төв эмнэлэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн төвийн дарга/захирал/цаашид Б тал гэх/-ийг төлөөлж... ССЭМГХ-ийн албан дарга албан тушаалтай ... Октөбр 6 ... овогтой ... Дугаар ... нар Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2017 - 2020 оны тэргүүлэх чиглэл, 2017 оны гадаад сургалтын төлөвлөгөө батлах тухай" А/312, Эрүүл мэндийн сайдын 2014 оны "Журам батлах тухай" 119 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам"-ын 3.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны сургалтын хяналтын тоо, зардал батлах тухай" А/188, Эрүүл мэндийн сайдын 2017 оны Сургалтын төлөвлөгөө, санхүүжилтийн эх үүсвэр, зардлын төсөв батлах тухай" А/423 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

1.2. Б тал нь А талын баталсан төсвийн дагуу эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтний төгсөлтийн дараах гадаад сургалтыг хамтран зохион байгуулна.

Хоёр. Гэрээний хугацаа



2.1. Талууд хугацааг харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.

2.2. Гэрээний хугацаа 2017 оны 11 дугаар сарын 24-с 2017 оны 12 дугаар сарын 30-ны хооронд байхаар харилцан тохиролцсон болно.

2.3 Сургалтад хамрагдах нийт 2 дот - Минжжогчмо  
- шийш, ямар бүтэцтэй шийшээр) гурвалээр сурагдах  
эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны замын зардал /онгоцны билет-2 талдаа/ зам хоног /хоол/, хот доторх унааны зардал/ 8.018.388.00 ₮ Наймаа сай арван найсанд  
Мелла гурван зуу найх наймаа Мелла төгсө  
төгрөг байна.

2.4 Замын зардлын төлбөрийг /онгоцны билет-2 талдаа/ А тал сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны тоогоор урьдчилан захиалж, төлбөрийг шилжүүлнэ.

2.5 Зам хоног, унааны зардлыг Б талаас нэхэмжлэл ирүүлсний дараа тухайн байгууллагын Галснт банкн дахь (РД: 9129367)-ийн 1105119594 тоот дансанд... шилжүүлнэ.

2.6 Замын зардлын төлбөрийг зорчигчийн суугчийн тасалбараар, тухайн байгууллагын дансанд шилжүүлсэн зам хоног, хот доторх унааны зардлыг зарцуулсан тайлангаа баримтаар баталгаажуулан сургалт дууссаны дараа 7 хоногт багтаан А талд хүргүүлнэ.

#### Гурав. А талын эрх, үүрэг

3.1. Гэрээнд заасны дагуу Б талаас ирүүлсэн албан бичгээр эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны нэрс, холбогдох мэдээллийг судалж суралцах чиглэл, шаардлагыг хангасан эсэхийг хянана.

3.2. А тал нь Б талтай хамтран төгсөлтийн дараах гадаад сургалтын гэрээний нийтлэг үндэслэлд заасны дагуу суралцах шаардлага хангасан эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтнийг тогтоосон хугацаанд тухайн орны сургалтын байгууллагад суралцах боломжоор хангаж, гэрээ байгуулан сургалтад явуулах ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулна.

3.3 Сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны замын зардал /онгоцны билет 2 талдаа/, зам хоног /хоол/, хот доторх унааны зардлыг зохих журмын дагуу олгоно.

3.4 Суралцагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн аливаа хохирлыг А тал хариуцахгүй

#### Дөрөв. Б талын эрх, үүрэг

4.1. Гэрээний нийтлэг үндэслэлд заасны дагуу суралцах чиглэл, шаардлагыг хангасан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны нэрс, гадаадын эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээ, холбогдох мэдээллийг албан бичгээр А талд хүргүүлнэ.

4.2. Өөрсдийн хамтын ажиллагааны хүрээнд сургалтыг зохион байгуулах байгууллагуудтай холбогдож, төгсөлтийн дараах гадаад сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтын сургалтын хөтөлбөрийг суралцах чиглэлийн дагуу хамтран боловсруулан баталгаажуулж А талд хүргүүлнэ.

4.3. Сургалтын төлбөр, байрны төлбөрийг өөрсдийн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын эрүүл мэндийн байгууллагаас гаргуулах ажлыг зохион байгуулна.



4.4 Сургалтыг тогтоосон хугацаанд чанартай, үр дүнтэй зохион байгуулан сургалтын явцын тайланг сургалт эхэлсэнээс хойш 7 хоногийн дотор, төгсөж ирсэнээс хойшхи төгсөлтийн тайланг 7 хоногийн дотор, үр дүнгийн тайланг 3 дахь сард, 6 дахь сард тус тус А талд хүргүүлнэ. .

4.5. Сургалтын явцад гадаадын эрүүл мэндийн байгууллагатай холбогдож суралцагч нарын идэвхтэй оролцоо, ирц зэрэгт хяналт тавина.

4.6. Сургалтын чанар, зохион байгуулалтын талаар гадаадын сургалт эрхлэх байгууллагад санал гаргах, шаардлага тавина.

4.7 Суралцагч нарыг эргэн ирэх, визны хугацааг мөрдөх тал дээр Б тал бүрэн хариуцлага хүлээж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.8 Төгсөлтийн дараах гадаад сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны сургалтын үр дүнг тооцон нэгдсэн тайлан, санхүүгийн тайланг эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нараар баталгаажуулан 2017 оны 12 дугаар сарын 15 –ны дотор А талд албан бичгээр хүргүүлнэ.

### Тав. Бусад зүйл

5.1. Энэхүү гэрээ нь эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.


5.2. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, А тал 1 хувь, Б тал 1 хувийг хадгална.

5.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

5.4. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.

А талыг төлөөлж:


Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн албаны дарга

  
3. Наранбаатар

Утас:

2017 оны .....-р сарын .....-ны өдөр

Б талыг төлөөлж:

ЭСЧТ-ийн Сургалт Агуулам, 

Эрхлэх мэргэжилтэн, гадна

Харилцааны ажилтан дарга

Утас: 8881-7167

2017 оны 11-р сарын 24-ны өдөр